



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛЭС**

2021 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 20 дугаар хуралдааны тэмдэглэлд:

**ХХ.8.ХЭЛЭЛЦСЭН НЬ:**

Булган аймагт хэрэгжсэн дулааны станц, дулааны шугам сүлжээний ажилд оруулсан улсын төсвийн санхүүжилт болон хувийн хэвшлээс оруулсан хөрөнгө оруулалтыг тооцож, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байгуулах тухай асуудлаар байгуулагдсан Ажлын хэсгийн хувийн хэвшилтэй хэлцэл хийж, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байгуулах асуудал боломжгүй болсон талаарх саналын тухай.

**ШИЙДВЭРЛЭССЭН НЬ:**

1. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Булган аймагт хэрэгжсэн дулааны станц, дулааны шугам сүлжээний ажилд улсын төсвийн санхүүжилтээр олгосон 3,800,000,000.00 (гурван тэрбум найман зуун сая) төгрөгийг барагдуулах асуудлыг Сангийн яам, Эрчим хүчний яам болон холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэхийг Ажлын хэсэгт үүрэг болгох;

2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Булган аймагт хэрэгжсэн дулааны шугамын өргөтгөл, дэд станц болох 842,208,000.00 (найман зуун дөчин хоёр сая хоёр зуун найман мянган) төгрөгийн хөрөнгийг орон нутгийн өмчид шилжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Д.Нарангэрэлд үүрэг болгох нь зүйтэй гэж үзэв.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



132002068  
Huraldaanii material\2021 on\2021.12.02-20-r huraldaan.docx